

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дархан АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/17/НА-СА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: **Б.Алтанзул**
Утас: **9939-7390**
Цахим хаяг: Altanzulby@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.03.15 № 237
танай 2022.02.16 -ны № 19 -Т

“ДАРХАН АЗЗА” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.БАЯСГАЛАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дархан АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Компанийн жилийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасныг Зам тээврийн хөгжлийн яамнаас 91.9 хувьтай дүгнэсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эвсэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

009020328

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

Нэг. Санхүүгийн ба зорилтот түвшний гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	634,058,324.48	726,526,501.53
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,527,033,873.76	1,417,799,305.71
	Нийт хөрөнгийн дүн	2,161,092,198.24	2,144,325,807.24
	Нийт өр төлбөрийн дүн	1,102,553,618.36	1,070,433,280.81
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,058,538,579.88	1,073,892,526.43
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,161,092,198.24	2,144,325,807.24
Орлогын дэлгэрэнгүй тайлан			
	Борлуулалтын орлого (цэвэр)	2,524,891,218.73	1,547,494,153.09
	Борлуулалтын өртөг	2,294,820,208.90	1,316,471,285.21
	Нийт ашиг (алдагдал)	230,071,009.83	231,022,867.88
	Бусад орлого, зардал	213,148,528.13	225,449,750.60
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	16,922,481.70	5,573,117.28
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	977,636,520.20	1,068,876,720.88
	Тайлант оны үр дүн	15,230,233.53	5,015,805.55
	Эцсийн үлдэгдэл	1,058,538,579.68	1,073,892,526.43
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Мөнгөн орлогын дүн	2,798,042,841.44	1,874,640,485.00
	Мөнгөн зарлагын дүн	2,498,489,977.59	1,971,481,893.38
	Үндсэн үйл ажиллагааны ЦМГ	299,552,863.85	(96,841,408.38)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(194,340,900.00)	(1,282,000.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(4,710,000.00)	(1,523,020.00)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	100,501,963.85	(99,646,428.38)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,258,561.97	113,760,525.82
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,760,525.82	14,114,097.44
Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл			
	Нийт орлого	2,526,158,946.00	1,548,609,900.00
	Борлуулалтын орлого	2,524,891,218.73	1,547,494,000.00
	Үйл ажиллагааны бус орлого	1,267,727.27	1,115,900.00
	Нийт зардал	2,509,846,534.76	1,549,036,782.72
	Олз гарцын дүн	610,070.46	6,000,000.00
	Татварын өмнөх ашиг (алдагдал)	16,922,481.70	5,573,117.28

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1971 оны 10 дугаар сарын 15-ны 328 дугаар тогтоолоор Дархан хотод зам барилга ашиглалтын контор нэртэйгээр байгуулагдан, Засгийн газрын 2006 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 173 тоот тогтоолоор “Дархан АЗЗА” ТӨХК-ийг байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Дархан АЗЗА” ТӨХК үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.4.9 дэх заалтуудтай, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т дэх заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 159,310.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,181.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 157,129.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 157,129.5 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг бус гэж үзлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар шинэ жилийн баярын хүлээн авалтад 280.0 мянган төгрөгийг зарцуулсан, ажиллаагүй хугацаанд ЭБАТ-ын хавсран ажилласны нэмэгдлийн 66.4 мянга, томилолтоор ажилласан болон сул зогсолтын үед хоол унааны 1,835.0 мянга, нийт 1,901.4 мянган төгрөгийг олгосон, нийт 2,181.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх асуудал гараагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2021 онд зохион байгуулсан тендерүүдэд үнэлгээний хороог байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасан бүрэлдэхүүнийг оролцуулалгүйгээр томилсон байна.

Өгсөн зөвлөмж: Тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасан бүрэлдэхүүнийг оролцуулан томилж байх.

2. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 475,350.0 мянган төгрөгийн 20 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байна. Энэ нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт “тухайн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллах

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: 157,129.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн 2 шийдвэрийг мэдээлээгүй, худалдан авах ажиллагааны тайланг бүтэн жилээр мэдээлэх 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.4.9 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд мэдээлээгүй 157,129.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн 2 шийдвэрийг нөхөж байршуулах, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх

5.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

5.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(мянган төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	5	159,310.9	-	-	2	2,181.4	-	-	3	157,129.5
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	5	159,310.9	-	-	2	2,181.4	-	-	3	157,129.5